



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/ЗНЧ

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Булган Мээж ОНӨХХК-ний харьяа цэвэрлэх байгууламжийн насос худалдан авах (Зш) нийлүүлэгчээр шалгарсан “Эс Би Жи электрик” ХХК-тай 95,400,000 (ерэн таван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг “Булган Мээж” ОНӨХХК-ийн захирал (Г.Ганбаатар)-д олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авах, данс бүртгэлд тусгахыг “Булган Мээж” ОНӨХХК-ийн захирал (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Эс Би Жи электрик” ХХК-ийн захирал (Г.Санжмятав)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ




Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010448

05 дугаар сарын

Аймгийн Засаг даргын 2024 оны
Сныний өдрийн А/З/Н дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	18 сар	Г.Ганбаатар
2	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
3	Бараа нийлүүлэх хугацаа	2024.05.15-2024.07.01	Г.Ганбаатар